


## Нээлхийг битүүмж сайтай байлга.

2023 оны 10 сар



*Резиний савны нээлхийгээр уур гадагшилснаас хойш 6 секундйн дараа (Лавлах материал: ХАБ-ын ослын тайлангийн дугаар. 2021-04-I-O)*

2021 оны 4 сарын 8-нд Охайо мужийн Колумбус хот дах резиний үйлдвэрийн реакторт шатамхай нафтаны уур болон шингэн резиний холимгийн даралт нэмэгдэж реакторын нээлхийгээр цацагдсан. Нафтаны уур алдагдсанаас шатамхай уур бүхий үүл үүсэж, барилгын дотор болон гадна талд тархсан. Оператор ослын зогсоох товчлуурыг дарах гэж оролдсон боловч уур манан дундаас товчлуурыг олж чадалгүй амьсгал нь боогдож эхэлсэн. Мөн халуун резинд шүршигдсэн байсан. Ингээд барилгыг орхиж гарсан бөгөөд хоёр минутын дараа шатамхай уур тэсэрч гал гарсан.

Нэг ажилтан амь насаа алдаж, 8 ажилтан гэмтэж ойролцоох эмнэлэгт хүргэгдсэн. Тэсрэлтийн улмаас ойролцоох барилгууд доргиж, нэг аж ахуйн нэгжид хохирол учирсан. Резиний үйлдвэр эвдэрч сүйдсэн тул уг ослын дараа үйлдвэрийг буулгасан.

### Та мэдэх үү?

- Боолт, хавчаар дутуу, эсвэл боолт, хавчаарыг буруу чангалсны улмаас нээлхий болон бусад төрлийн таг зураг төслийн хүчин чадлаасаа бага даралтад битүүмжээ алддаг.
- Жийрэг бас чухал үүрэгтэй. Үзүүлэлт нь тохирсон, зөв суулгасан, чанар нь муудаагүй байж битүүмж сайтай байна.
- Даралт суллах хавхалга ажиллахаас өмнө нээлхийн битүүмжлэл алдагдсан өөр нэг ослын талаар 2021 оны 3 сарын мэдээллээс уншаарай.
- Дэгдэмхий бодис, уусгагчийг буцлах хэмээс нь их хэмтэй үйлдвэрлэлийн процесст оруулбал маш хурдан буцалж, хурц уур үүсгэдэг. Ингэвэл савны даралт богино хугацаанд огцом нэмэгдэнэ.
- Бүх холболт зохих ёсоор битүүмжлэл сайтай байвал саванд үүссэн илүүдэл даралт нь даралт суллах системээр дамжин аюулгүй цэгт гадагшилна.

### Та юу хийх ёстой вэ?

- Савны нээлхийг найдвартай битүүмжлэх талаар мэддэг байх. Хэдэн боолт, хавчаар ашиглах, хэр их чангалах зэргийг мэддэг байх нь битүүмжлэл алдагдахаас сэргийлэхэд тун чухал.
- Нээлхий, тагийг зөв битүүмжлэх арга замыг үйл ажиллагааны журамд тодорхой заасан байх. Ийм мэдээлэл байхгүй байвал ахлах ажилтандаа мэдэгдэж нэмүүлээрэй.
- Жийргийн төрөл, материал, үзүүлэлт зэргийг мөн нээлхийг битүүмжлэх журамд тодорхой заасан байх.
- Фланецаар материал алдагдах үед исгэрэх, шүгэлдэх чимээ гардаг. Ийм чимээ сонсогдвол тухайн хэсгийг орхин гарч, ахлах ажилтнаасаа заавар аваарай.

**Нээлхий, таг зэрэг нь битүүмж сайтай байх ёстой!**